



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/57

Шивээговь сум

Хаягийн мэдээлэл шалгах, засварлах,
зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Засаг даргын Тамгын газрын дарга
Ажлын хэсгийн орлогч дарга:	Улсын бүртгэгч
Нарийн бичгийн дарга:	Газрын даамал
Гишүүд:	1 дүгээр багийн Засаг дарга 2 дугаар багийн Засаг дарга Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын хэсгийн хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлыг чанартай зохион байгуулах, дээд шатны байгууллагад холбогдох тайлан мэдээг хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

4212 155